

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ ОНӨААТҮГ-ЫН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАНД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Аудитын код: ХАК-2022/67/НА-СА-ОНА

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2022 он

Бэст фортуна аудит" ХХК-ийн

Захирал: Ж.Оюунцэцэг

Утас: 324348, 89116465, 98056465

Цахим хаяг: fortune2009audit@gmail.com

Аудитор Н.Эрдэнэбат

Утас: 324348, 991316001

Аудитор: Ч.Дуламсүрэн

Утас: 324348, 86689446

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1.Аудитын санал, дүгнэлт	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	6
2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан	7
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.5 Техник, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан	9
3.Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Дотоод хяналт	10
3.3 Санхүүгийн тайлангийн үзэл баримтлал	10
3.4. Материаллаг байдал	10
4. Санхүүгийн тайлангийн тодруулга	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин	11-12
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого	13-14
4.4 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл	15-16
5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	16
5.1 Шилэн дансны мэдээлэл	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
6.1 Завсрын аудитын үр дүн	17
6.2 Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт	17
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал	17
8. Аудитын илрүүлэлт	17
8.1 Залруулсан алдаа	17
8.2 Төлбөрийн акт	17
8.3 Албан шаардлага	18
8.4 Зөвлөмж	18-19
9. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл	20-22

Товчилсон үгийн жагсаалт

АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТА	Инженер техникийн ажилтан
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НӨАУГ	Нийслэлийн өмчийн ашиглалт удирдлагын газар
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБОНӨТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 195
тэнэй _____-ны № _____-г

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
О.ГАНБААТАР ТАНАА

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын
2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын
тайлан, санал дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт: 22 хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002030860



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Сойлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022.03.15 № 700
танай _____-ны № _____-т

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА О.ГАНБААТАР
ТАНАА

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитаар илэрсэн 216.8 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт, 2,112,908.1 мянган төгрөгийн зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх 3 албан шаардлагыг хүргүүлж байна.

Төлбөрийн акт, албан шаардлагын биелэлтийг заасан хугацаанд хэрэгжүүлж, хариу ирүүлнэ үү.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

М.ЭРДЭНЭЖАРГАЛ



012030274

© Copyright 2020 by Audit.gov.mn. All rights reserved.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2022. 03. 15 № 696

танай _____-ны № _____-т

"ЗОРЧИГЧ ТЭЭВЭР ГУРАВ"
ОНӨААТҮГ-ЫН ДАРГА
О.ГАНБААТАР ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

"Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Аудитын гол асуудлууд

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудлууд гэж тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын хувьд аудитын гол асуудал нь үнэ тариф, төсвийн санхүүжилт, автобусны парк шинэчлэлтээс хамаарсан өрийн асуудлыг аудитын гол асуудал гэж үзлээ.

Санхүүгийн тайланд хийсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн дүгнэлт гаргаагүй болно.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд 1 зорилтын хүрээнд 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 91.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан**2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан**

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,357,939,388.12	246,364,689.67
1.1.2	Дансны авлага	5,250,155,351.90	53,038,892.37
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	4,838,220.00	5,830,810.04
1.1.6	Бараа материал	1,142,958,199.05	1,123,474,991.02
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18,996,156.55	2,167,628,506.24
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	11,774,887,315.62	3,596,337,889.34
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,283,303,642.79	20,846,166,803.13
1.2.2	Биет бус хөрөнгө	1,089,024,825.00	277,297,325.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	3,372,328,467.79	21,123,464,128.13
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,147,215,783.41	24,719,802,017.47
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,730,827,481.26	2,613,874,140.54
2.1.1.2	Цалингийн өглөг		4,439,466.78
2.1.1.3	Татварын өр	668,199,594.30	824,870,546.83
2.1.1.4	НДШ - ийн өглөг	1,832,294,433.49	2,507,754,927.43
2.1.1.6	Хүүний өглөг		98,151,943.66
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	6,197,250,000.43	4,110,070,075.85
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	193,077,656.20	31,056,727.17
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,621,649,165.68	6,723,654,226.41
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	11,089,933,220.45	24,922,463,454.26
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,089,933,220.45	24,922,463,454.26
2.2	Өр төлбөрийн нийт дүн	22,711,582,386.13	31,646,117,680.67
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	2,065,596,348.11	2,065,596,348.11
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	292,516,631.66	292,516,631.66
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	1,085,126,700.00	275,626,700.00
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(11,007,606,282.49)	(13,026,618,944.82)
2.3.11	Эздийн өмчийн дүн	(7,564,366,602.72)	(10,392,879,265.05)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,147,215,783.41	24,719,802,017.47

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Мөрийн дугаар	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	10,254,414,460.79	11,504,630,473.65
2	Борлуулалтын өртөг	11,523,404,188.31	12,024,620,655.13
3	Нийт ашиг(алдагдал)	(1,268,989,727.52)	(2,353,426,579.63)
4	Түрээсийн орлого	3,790,000.00	
5	Хүүний орлого	1,019,080.26	
8	Бусад орлого	200,000,000.00	1,898,752,900.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	1,168,113,983.42	1,057,061,840.47
11	Санхүүгийн зардал		1,768,507,600.10
12	Бусад зардал	120,242,570.56	546,959,039.96
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	3,117.32	(4,289.44)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	(334,078,247.85)	(25,242,610.88)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	(2,686,612,331.77)	(2,019,012,662.33)
19	Орлогын татварын зардал	101,908.04	-
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(2,686,714,239.81)	(2,019,012,662.33)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(2,686,714,239.81)	(2,019,012,662.33)
23	Бусад дэлгэрэнгүй орлого		
24	Орлогын нийт дүн	(2,686,714,239.81)	(2,019,012,662.33)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/						
№	ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	372,890,538.07	809,500,000.00	(8,401,265,949.09)	(5,153,279,062.91)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				80,373,906.41	80,373,906.41
3	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	372,890,538.07	809,500,000.00	(8,320,892,042.68)	(5,072,905,156.50)
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,686,714,239.81)	(2,686,714,239.81)
5	Бусад дэлгэрэнгүй орлого					-
6	Өмчид гарсан өөрчлөлт					-
7	Зарласан ногдол ашиг					-
8	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн		(80,373,906.41)	275,626,700.00		195,252,793.59
9	2020 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	1,085,126,700.00	(11,007,606,282.49)	(7,564,366,602.72)
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					-
11	Залруулсан үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	1,085,126,700.00	(11,007,606,282.49)	(7,564,366,602.72)
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)				(2,019,012,662.33)	(2,019,012,662.33)
13	Бусад дэлгэрэнгүй орлого					-
14	Өмчид гарсан өөрчлөлт			(809,500,000.00)		(809,500,000.00)
15	Зарласан ногдол ашиг					-
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн					-
17	2021 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	2,065,596,348.11	292,516,631.66	275,626,700.00	(13,026,618,944.82)	(10,392,879,265.05)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Мөрийн дугаар	ҮЗҮҮЛЭЛТ	/төгрөгөөр/	
		2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	21,178,844,228.51	10,870,097,167.56
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	1,317,288,893.54	1,380,341,220.34
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	34,011,328.10	27,532,977.40
	Татаас, санхүүжилтийн орлого	14,101,412,339.92	9,415,912,808.00
	Бусад мөнгөн орлого	5,726,131,666.95	46,310,161.82
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	15,686,621,425.53	10,216,723,821.37
	Ажиллагчдад төлсөн	3,485,312,101.35	3,348,733,419.88
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	207,505,517.07	367,896,338.11
	Бараа материал худалдан авахад төлсөн	223,384,242.50	261,628,481.80
	Ашиглалтын зардалд төлсөн	149,906,474.29	205,121,109.59
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	5,479,981,169.42	3,213,195,527.87
	Хүүний төлбөрт төлсөн		1,209,595,999.33
	Татварын байгууллагад төлсөн	88,986,517.70	166,484,165.16
	Даатгалын төлбөрт төлсөн	47,274,575.00	65,669,340.00
	Бусад мөнгөн зарлага	6,004,270,828.20	1,378,399,439.63
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	5,492,222,802.98	653,373,346.19
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	1,019,080.26	-
	Хүлээн авсан хүүний орлого	1,019,080.26	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,072,597,042.60	17,611,796,717.76
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	144,123,000.00	17,611,796,717.76
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	4,928,474,042.60	-
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(5,071,577,962.34)	(17,611,796,717.76)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	4,928,474,042.60	12,311,796,717.76
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	4,928,474,042.60	12,311,796,717.76
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	464,948,044.64
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	-	464,948,044.64
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,928,474,042.60	11,846,848,673.12
5	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	5,349,118,883.24	(5,111,574,698.45)
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	8,820,504.88	5,357,939,388.12
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,357,939,388.12	246,364,689.67

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшинний гүйцэтгэл

/мянган төгрөг/

	Үзүүлэлт	Хэмжих нэгж	2020 оны гүйцэтгэл	2021 оны			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	1. Нийт орлого	Төгрөг	10,459,228.58	20,877,368.15	13,403,384.79	7,473,983.36	64
1	Шугамын орлого	Төгрөг	1,317,560.97	3,990,400.19	2,286,000.00	1,704,400.19	57.3
2	Санхүүжилтийн орлого	Төгрөг	6,893,716.79	13,567,360.64	6,716,548.10	6,848,812.54	49.5
3	Нөхөн олговор - хөнгөлөлттэй зорчигчид	Төгрөг	1,119,084.29	2,394,240.11	643,767.00	1,750,473.11	26.9
4	Түрээсийн орлого	Төгрөг	3,790.00	5,054.40	1,734.00	3,320.40	34.3
5	Үйл ажил-ны бусад орлого	Төгрөг	227,826.50	23,062.81	21,145.00	1,917.81	91.7
6	Хөрөнгө оруулалтын орлого	Төгрөг	897,250.00	897,250.00	3,732,190.69	(2,834,940.69)	416
	2. Нийт зардал	Төгрөг	12,811,864.55	24,799,986.11	15,422,397.80	9,377,589.02	62.3
1	Цалин	Төгрөг	4,516,522.66	6,870,445.25	4,209,802.47	2,460,642.78	63.1
2	НДШ	Төгрөг	612,440.08	892,913.94	588,161.25	304,752.69	65.9
3	Шатахуун	Төгрөг	3,097,320.57	3,951,620.59	2,680,901.15	1,270,719.44	67.8
4	Тосолгооны материал	Төгрөг	155,263.06	237,579.40	175,525.27	62,054.13	73.9
5	Салбаг хэрэгсэл	Төгрөг	1,459,954.96	1,776,692.50	1,028,705.79	747,986.71	57.9
6	Дугуйн зардал	Төгрөг	157,980.58	181,000.00	72,352.28	108,647.72	40.0
7	Хөдөлмөр хамгаалал	Төгрөг	93,539.55	226,485.44	66,776.80	169,708.64	25.1
8	Үндсэн хөрөнгийн элэгдэл	Төгрөг	1,896,880.04	3,068,596.79	3,479,029.36	410,432.57	113.4
9	Бичиг хараглал	Төгрөг	38,594.80	38,594.80	19,126.62	19,468.18	49.6
10	Хангамжийн зардал	Төгрөг	62,096.82	154,430.30	80,054.68	74,375.62	51.8
11	Цэвэрлэгээ, үйлчилгээний зардал	Төгрөг	55,852.37	250,000.00	230,679.40	19,320.60	92.3
12	Засвар үйлчилгээ	Төгрөг	43,623.49	41,300.00	10,187.45	31,112.55	24.7
13	Цахилгаан	Төгрөг	67,382.39	439,413.25	147,132.29	292,280.97	33.5
14	Ус	Төгрөг	11,984.98	13,000.00	8,136.62	4,863.38	62.6
15	Халаалт дулаан	Төгрөг	65,216.18	65,000.00	51,314.88	13,685.12	78.9
16	Харилцаа холбоо	Төгрөг	14,469.44	15,560.00	10,487.11	5,072.89	67.4
17	Үндсэн хөрөнгийн татвар	Төгрөг	26,937.98	-	-	-	-
18	Газрын төлбөр	Төгрөг	11,785.75	2,094.55	2,094.55	-	100.0
19	Тээврийн хэрэгслийн татвар	Төгрөг	11,318.15	16,826.70	14,383.46	2,443.24	85.5
20	Даатгалын үйлчилгээ	Төгрөг	30,621.85	94,350.00	45,546.15	48,803.85	48.3
21	Албан томилолт	Төгрөг	630.00	-	-	-	-
22	Сургалт сурталчилгаа	Төгрөг	37,845.11	39,700.00	9,943.70	29,756.30	25.0
23	Тэтгэвэр тэтгэмж, шагнал	Төгрөг	110,770.64	145,005.00	122,037.75	22,967.25	84.2
24	Гадны үйлчилгээ	Төгрөг	170,486.00	160,072.00	150,774.00	9,298.00	94.2
25	Үйл ажиллагааны бусад	Төгрөг	62,245.37	88,140.00	78,790.57	9,349.43	89.4
26	Хүүгийн орлогын татварын зардал	Төгрөг	101.91	135.88	-	135.88	-
27	Зээлийн хүү /цахилгаан автобус/	Төгрөг	-	5,637,029.72	1,796,453.85	3,840,577.23	31.9
28	Түрээсийн зардал	Төгрөг	-	594,000.00	354,000.00	240,000.00	59.6
29	Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	Төгрөг	-	-	25,245.60	-	-
	3. Ашиг/алдагдал	Төгрөг	(2,352,635.99)	(3,922,617.96)	(2,019,012.67)	(1,903,605.27)	51.5
	Орлогын нэг төгрөгт ногдох зардал		1.22	1.19	1.2	0.04	96.9

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад хууль, тогтоомжуудыг мөрдөж ажиллах, байгууллагын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өглөг, авлагыг барагдуулах, үлдэгдлийг шийдвэрлүүлэх, Сангийн сайдын баталсан нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, журмыг мөрдөх, үндсэн болон нэмэгдэл цалин хөлсийг зөв тооцож олгохтой холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Бэст фортуна аудит” ХХК-ийн аудитор Н.Эрдэнэбат, аудитор Ч.Дуламсүрэн нар гүйцэтгэж, чанарын хяналтыг захирал Ж.Оюунцэцэг, НТАГ-ын аудитын менежер С.Гантөгс, хэлтсийн дарга, аудитын менежер З.Мөнхбаяр, нар тус тус хэрэгжүүлсэн.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланг “Бэст фортуна аудит” ХХК-д 2021 оны 03 дугаар сарын 04 -ны өдрийн 01/78 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Дотоод хяналт

Компанийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Тус компанийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод хяналт шалгалтын хэлтэс тайлант онд 36 ажил гүйцэтгэхээр төлөвлөж, төлөвлөсөн ажлаа 91.9 хувь биелүүлсэн гүйцэтгэлийн тайлан ирүүлсэн боловч хөрөнгө, санхүү, зардал хэмнэх талаар ажил хийсэн талаар дурдаагүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудиторроос шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны нийт зардлаар сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл 115,234.0 мянган төгрөг гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 11,523,404.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 115,234.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн шатанд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4. Санхүүгийн тайлангийн тодруулга

4.1 Байгууллагын үйл ажиллагаа

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын зорилгыг *"зорчигч тээврийн үйлчилгээг орчин үеийн түвшинд хүргэж хөгжүүлэх, чанар үр дүнг дээшлүүлэх, нийслэлийн иргэд зорчигчдод шуурхай, боловсон, ая тухтай үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх, үйлчилгээний менежментийг сайжруулах, төсөл хэрэгжүүлэх, хэтийн төлөвийг тодорхойлох замаар Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээг дэлхийн жишигт хүргэхэд оршино."* гэжээ.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг:

- Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээг иргэдэд түргэн шуурхай боловсон ая тухтай хүргэх
- Нийтийн зорчигч тээврийн үйлчилгээний стандартыг мөрдөж үйлчилгээний ёс зүйн хэм хэмжээ, хууль тогтоомж, дүрэм журмыг баримтлан ажиллах
- Нийтийн зорчигч тээврийн үйл ажиллагааг явуулахад шаардагдах боловсон хүчин (ИТА, жолооч, шалгагч)-ийг бэлтгэх, мэргэжил боловсролыг дээшлүүлэх чиглэлээр сургалтын үйл ажиллагаа явуулах
- Үндсэн үйл ажиллагааны хувьд ашигтай ажиллах
- Нийтийн зорчигч тээврийн хэрэгслүүдэд хийх их болон урсгал засварын нэгдсэн төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ашиглалтад хяналт тавих гэж тодорхойлжээ.

Байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээнд нийтийн тээврийн үйлчилгээ. статустай байна. Өмчийн 100 хувийг Нийслэлийн Өмчийн харилцааны газар эзэмшиж байна.

4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 1965 оны 126 дугаар тогтоолоор анх үндэслэн байгуулагдаж, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2018 оны 73 дугаар тогтоолоор Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас салж Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нэртэй болсон байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд *"Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;..."* гэсэн заалттай нийцэж байна.

Компанийн удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн тогтоолоор 5 хүний бүрэлдэхүүнтэй томилж байгаа нь Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэн эрх, 76.1.8 *"компанийн гүйцэтгэх удирдлагыг сонгох, өөрчлөх, түүний бүрэн эрхийг тогтоох"*; 77 дугаар зүйл Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах

зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, 77.1."Энэ хууль болон компанийн дүрмээр тогтоосон журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг сонгоно" заалттай нийцэж байна.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 25.2 сая төгрөгөөр тогтоосон нь ТБОНӨТХ-ийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам"-ын 3.7. "...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна" гэсэн заалттай нийцэж байна.

Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.10. "Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нээгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно." гэж заасан байна. Энэ хүрээнд нийтийн тээврийн үйлчилгээний автобусны парк шинэчлэлт, нийтийн тээврийн шугамын үйлчилгээний цаг, рейсийн алдагдалгүй, карт уншигчийн зөрчлийг бууруулах, автобусны техникийн саатлыг 2020 оноос 10 хувиар бууруулах, санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулах, төсөв санхүүгийн сахилга батыг чанд мөрдүүлэх, өртөг зардлаа бууруулах, хэмнэлтийн бодлого хэрэгжүүлэх 5 бүлэг 85 арга хэмжээнүүдийг төлөвлөн ажилласны дүнд алдагдал буурсан байна.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" тогтоолын 1.3. "Төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлгэ дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гараахгүй байх;"-д заасны дагуу дотоод зохион байгуулалтын бүтцийг өөрчлөх, чиг үүргийн давхардлыг арилгаж орон тоог бууруулах боломжгүй бөгөөд удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан ТУЗ-өөс тогтоосон байна.

Байгууллага өр ихтэй, хотын төвөөс хотын зах руу нүүсэн нь ажилчдын сэтгэл зүйд хүндээр нөлөөлж мэргэшсэн жолооч, мэргэжилтэй засварчин, мэргэжлийн инженер техникийн ажилчид олноор, өөрийн хүсэлтээр ажлаас чөлөөлөгдөж туршлагатай боловсон хүчний дутагдалд орсон байна.

Ажиллах боловсон хүчнийг тогтвортой ажиллуулах, ажилчдын нийгмийн асуудал, цалин хөлс, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, ажиллах нөхцөлийг сайжруулах арга хэмжээг зорилтот түвшиндээ багтаан зохион байгуулж, компанийн засаглалын хүрээнд төлөвлөн, зардлаа багасгах нь эн тэргүүний зорилт болж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай"
- Монгол Улсын Засгийн Газрын 2021 оны 124 дүгээр тогтоол "Босго үнэ шинэчлэн батлах тухай"
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"

4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	5,357,939.4	246,364.7	(5,111,574.7)
Дансны авлага	5,250,155.4	53,038.9	(5,197,116.5)
Татвар, НДШ – ийн авлага	4,838.2	5,830.8	992.6
Бараа материал	1,142,958.2	1,123,475.0	(19,483.2)
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	18,996.2	2,167,628.5	2,148,632.3
Үндсэн хөрөнгө	2,283,303.6	20,846,166.8	18,562,863.2
Биет бус хөрөнгө	1,089,024.8	277,297.3	(811,727.5)
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	15,147,215.8	24,719,802.0	9,572,586.2
Богино хугацаат өр төлбөр			-
Дансны өглөг	2,730,827.5	2,613,874.1	(116,953.4)
Цалингийн өглөг		4,439.5	4,439.5
Татварын өр	668,199.6	824,870.5	156,670.9
НДШ - ийн өглөг	1,832,294.5	2,507,754.9	675,460.4
Хүүний өглөг		98,152.0	98,152.00
Урьдчилж орсон орлого	6,197,250.0	4,110,070.1	(2,087,179.9)
Бусад богино хугацаат өр төлбөр	193,077.7	31,056.7	(162,021.0)
Богино хугацаат өр төлбөрийн дүн	11,621,649.3	10,190,217.8	(1,431,431.5)
Урт хугацаат өр төлбөр			-
Бусад урт хугацаат өр төлбөр	11,089,933.2	24,922,463.5	13,832,530.3
Урт хугацаат өр төлбөрийн дүн	11,089,933.2	24,922,463.5	13,832,530.3
Өр төлбөрийн нийт дүн	22,711,582.5	35,112,681.3	12,401,098.8
Эздийн өмч			-
Өмч: төрийн	2,065,596.3	2,065,596.3	-
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	292,516.6	292,516.6	-
Эздийн өмчийн бусад хэсэг	1,085,126.7	275,626.7	(809,500.0)
Хуримтлагдсан ашиг	(11,007,606.3)	(13,026,618.9)	(2,019,012.6)
Эздийн өмчийн дүн	(7,564,366.7)	(10,392,879.3)	(2,828,512.6)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	15,147,215.8	24,719,802.0	9,572,586.2

Касс дахь бэлэн мөнгө 310.2 мянга, банкан дахь мөнгө 6 харилцах дансанд 246,054.5 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл оны эхнээс 5,111,574.7 мянган төгрөгөөр буурсан нь 2021 онд худалдан авах автобусны төлбөр "Нанжин Голден драгон Бус" ХХК-д төлөгдсөнөөс шалтгаалжээ.

Дансны авлага 5,197,116.5 мянган төгрөгөөр буурсан нь БНХАУ-ын "Нанжин Голден драгон Бус" ХХК-аас 35 ширхэг автобус хүлээн авсантай холбоотой.

Авлагын үлдэгдэлд төлөгдөх хугацаандаа байгаа 45,729.6 мянган төгрөгийн, хугацаа хэтэрсэн 7,309.3 мянган төгрөгийн авлага байна. Найдваргүй авлагын нөөц байгуулаагүй байна.

НДШ-ийн авлагын үлдэгдэлд Хөдөлмөрийн чадвараа түр алдсан тэтгэмжийн авлага 5,830.8 мянган төгрөг байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 1,123,475.0 мянган төгрөг болж 19,483.2 мянган төгрөгөөр буурсан нь агуулахын үлдэгдлээс тайлант онд зарцуулагдсанаас шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй, илүүдэлтэй эко автобусны 21 төрлийн 155,980.0 мянга, daewoo автобусны 46 төрлийн 66,020.0 мянга, дахин нягталж тодруулах эко автобусны 22 төрлийн 37,400.0 мянга, daewoo автобусны 36 төрлийн 30,700.0 мянга, нийт 290,100.0 мянган төгрөгийн сэлбэг байна. Энэ нь нөөц их хэмжээгээр бэлтгэснээс шалтгаалсан байж болзошгүй гэж үзлээ.

Урьдчилж төлсөн тооцоо дансанд "Нанжин Голден драгон Бус" ХХК-аас худалдан авах автобусны төлбөр 2,167,628.5 мянган төгрөгийн урьдчилгаа төлж бүртгэсэн ба автобус тайлант онд бүрэн нийлүүлэгдээгүй байна. Урьдчилж төлсөн зардал дансны эхний үлдэгдэлд бүртгэлтэй 2020 оны 5 дугаар сард урьдчилж төлсөн даатгалын 18,996.2 мянган төгрөгийн зардал байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өссөн буурсан нь дараах шалтгаантай байна. Үүнд:

Тайлант онд 22,064,907.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан авч, 1,488,368.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталсан байна.

Үндсэн хөрөнгөөс Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/761 дүгээр захирамж, НӨАУГ-ын 2021 оны А/329 дугаар тогтоолоор нийт 1,488,368.1 мянган төгрөгийн өртөгтэй, 1,463,125.5 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 67 ширхэг хөрөнгийг акталж данснаас хассан байна.

Биет бус хөрөнгө 811,727.5 мянган төгрөгөөр буурсан нь Нийслэлийн засаг даргын шийдвэрээр автобусны тоог нэмэгдүүлж, парк шинэчлэлт хийхээр Тахилтад 46,860 м2 газар олгож, НӨАУГ-ын 2021 оны 5 дугаар сарын 24-ний 3/636 дугаартай шийдвэрээр, дуудлага худалдаагаар 24,901 м2 газар эзэмших эрхийг Камдер ХХК-д шилжүүлснээс шалтгаалжээ.

Дансны өглөгийн үлдэгдэлд Сод монгол ХХК-д төлөх 1,039,067.3 мянга, Шунхлай ХХК-д төлөх 922,089.7 мянга, Карс иннвшин ХХК-д төлөх сэлбэгийн өр 190,918.8 мянга, Хьюндэи ХХК-д төлөх сэлбэгийн өр 190,000.0 мянга, бусад байгууллагад төлөх 271,900.0 мянган төгрөгийн өглөг байна.

Цалингийн өглөг дансны үлдэгдэлд ТУЗ болон ажилчдын цалингийн 4,439.5 мянган төгрөгийн өглөг байна.

Татварын өглөг дансанд 824,870.5 мянган төгрөгийн ХХОАТ-ын өглөг байна.

Санхүүжилт хүрэлцэхгүйгээс шалтгаалан өмнөх онуудаас хуримтлагдсан 2,507,754.9 мянган төгрөгийн НДШ-ийн өглөгийн үлдэгдэлтэй байна.

Зээлийн хүүгийн өглөг дансанд 2021 оны 12 дугаар сарын сүүлийн 15 хоногийн өглөг байна.

Урьдчилж орсон орлого дансан дахь 4,110,070.1 мянга төгрөгийн үлдэгдэл нь 2022 оны 1 ба 2 дугаар сарын санхүүжилтийг урьдчилан авсан, 36 автобусны урьдчилгаа төлбөрийн элэгдэл хассан зөрүүшнээс шалтгаалжээ.

Урт хугацаат өр төлбөр дансанд 2018 онд Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн 6,145,592.8 мянга, Нийтийн тээврийн газраас 2021 онд шилжиж ирсэн 1,536,600.0 мянга, Хөгжлийн банкнаас 2021 онд авсан зээл 17,240,270.7 мянга, нийт 24,922,463.5 мянган төгрөгийн өр төлбөр байна.

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн 6,145,526.0 мянган төгрөгийн өр нь Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/582 дугаар захирамжаар Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн каунти, дэйвү 60 автобусны 6,145,592.8 мянга, Нийтийн тээврийн газраас 2021 онд шилжиж ирсэн ХАК-2022/67/НА-СА-ОНА

хүүхдийн 5 автобусны 1,536,666.7 мянга, нийт 7,682,259.5 мянган төгрөгийн өр эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй байна.

Шалгагдагч байгууллага Хөгжлийн банкнаас 2020 онд 4,928,500.0 мянга, 2021 онд 12,311,800.0 мянган төгрөгийн зээлийг цахилгаан автобус худалдан авах зориулалттай авч, зориулалтын дагуу зарцуулсан ба зээлийн эргэн төлөлт хийгдээгүй, зээлийн үлдэгдэл хэвээр байна. Хөгжлийн банкнаас авсан үндсэн зээл төлөгдөхгүй байгаа нь зээлдэгч буюу Нийслэлийн Засаг дарга *"үндсэн зээл, хүүгийн төлбөрийг жил бүр төсөвт тусган зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу банкна дахь өөрийн харилцах дансанд шилжүүлэн төлнө"* гэсэн гэрээний заалт хэрэгжээгүй, ковид-19 цар тахлын улмаас төсвийн орлого бүрдээгүйтэй холбоотой байна. Энэ нь нэмэгдүүлсэн хүү төлөх сөрөг үр дагавартай байна.

Зээлийн хүү төлөхөд зориулж 2021 оны төсвийн тодотголоор 1,800,00.0 мянган төгрөг батлагдаж, Нийслэлийн засаг даргын тамгын газраас санхүүжилт авснаас үндсэн зээлийн хүүд 1,781,300.0 мянга, нэмэгдүүлсэн хүүд 18,700.0 мянган төгрөг төлсөн байна.

Эзэмшигчийн өмчийн бусад хэсэг данс 809,500.0 мянган төгрөгөөр буурсан нь эзэмшлийн газраа Нийслэлийн Засаг даргын захирамжийг үндэслэн 2020 онд дуудлага худалдаагаар худалдаж 2021 онд хөрөнгийн данснаас хассанаас шалтгаалжээ.

Санхүүгийн тайланд зардал өртгийн талаарх мэдээллийг бэлтгэх зорилгын дагуу борлуулсан бүтээгдэхүүний өртөг, үйл ажиллагааны зардал, үйл ажиллагааны бус зардал, санхүүгийн зардал гэж ангилсан байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөг өмнөх онтой харьцуулахад 501,216.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь түрээсийн зардал 354,000.0 мянга, нүүлгэлттэй холбоотой зардал 54,500.0 мянга, түр барилгын зардал 92,716.5 мянган төгрөгөөс тус тус шалтгаалжээ.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь Нийслэлийн Засаг даргын шийдвэрээр Сүхбаатар дүүргийн 2 дугаар хорооны нутаг дэвсгэрээс Сонгинохайрхан дүүргийн Тахилтад шилжин байрших Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж байгаа объектын ажил дуусаагүйгээс одоогоор Сонгинохайрхан дүүргийн 41 дүгээр хороо, Баянхошууд байрлалтай "НБЧ" ХХК-ийн эзэмшлийн автобус паркад түрээсээр байрлаж байна.

Борлуулсан бүтээгдэхүүний өртөгт цалин, ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл, шатахуун, сэлбэг, засварын зардал, элэгдэл, түрээсийн зардал, бусад зардлуудыг хамруулсан байна.

4.4. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 3, 20 дугаар зүйлийн 20.1.3-д заасны дагуу Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулж, биелэлтийг хангах үүрэгтэй.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 02 дугаар тогтоолоор Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг баталсан байна. Тайлант оны нийт орлогыг 20,877,368.1 мянган төгрөгөөр, нийт зардлыг 24,799,986.1 мянган төгрөгөөр, 3,922,618.0 мянган төгрөгийн алдагдалтай байхаар тогтоосон байна. Үүнээс хөрөнгө оруулалтын арга хэмжээнд 897,250.0 мянган төгрөгийг төлөвлөсөн байна.

Нийслэлийн Засаг даргын 2021 оны А/872 дугаартай захирамжаар Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинг 7,198,752.9 мянган төгрөгөөр тодотгож 16,869,947.0 мянган төгрөг болсон байна.

Гүйцэтгэлээр 13,403,383.4 мянган төгрөгийн орлого, 15,422,396.1 мянган төгрөгийн зардал, 2,019,012.7 мянган төгрөгийн алдагдалтай ажилласнаар тайлагнасан байна. 2021 онд Нийслэлийн Засаг даргын захирамжаар цахилгаан автобусны парк шинэчлэлтийн төслийн хүрээнд 7,198,752.9 мянган төгрөгийн хөрөнгө оруулалт хийж, зээлийн хүүгийн ХАК-2022/67/НА-СА-ОНА

төлөлтөнд олгосон 1,898,752.9 мянган төгрөгийг орлогоор хүлээн зөвшөөрсөн нь санхүүгийн үр дүнд нөлөөлж, төлөвлөсөн алдагдлыг бууруулсан байна.

Их засвар, хөрөнгө оруулалт, техник зохион байгуулалтын арга хэмжээний төлөвлөгөөний дагуу 5 нэр төрлийн худалдан авах ажиллагаанд өөрийн эх үүсвэрээс 6,349.964.4 мянган төгрөгийн зардлыг санхүүжүүлсэн байна.

5. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ нь тайлант онд 149 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргасан тул албан шаардлага өгөв.

5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн Газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилтийг шалгахад ахмадуудад хүндэтгэл үзүүлсэн, хүүхдүүдэд хүүхдийн баяр, шинэ жилийн баяраар бэлэг өгсөн, спортын тэмцээн зохион байгуулсан, төрийн шагнал хүртэгсдэд шагнал урамшуулал олгосон зэргээр 39,494.0 мянган төгрөг олгосноос 21,724.0 мянган төгрөгийг зөрчилд тооцож, шалгагдагч байгууллагын тайлбар болон тайланд дурьдсан бодит байдлыг харгалзан албан шаардлага өгөв. Энэхүү зөрчлийн талаар шалгагдагч байгууллагаас доорх тайлбарыг ирүүлсэн. Үүнд: "Байгууллагын объект хотын 1 дүгээр зэрэглэлийн бүсээс хотын зах руу түрээсийн байранд түр байрлах болсон нь хамт олон болон ахмад насны тэтгэврийн ахмадуудын сэтгэл санаанд сөргөөр нөлөөлсөн тул тэдний сэтгэл зүйг дэмжих зорилгоор өмнөх жилүүдэд авч хэрэгжүүлж байсан нийгмийн арга хэмжээнүүдийг тасалдуулахгүй байх үүднээс дотоод журам, хамтын гэрээнд заасан ахмадын хүлээн авалт, хүүхдийн баярын бэлэг, Төрийн дээд шагнал хүртэгсдэд хүндэтгэл үзүүлэх, байгууллагын хөдөлмөрийн аварга, шилдэг ажилтан шалгаруулах, спортын тэмцээн зохиох зэрэг үйл ажиллагаанд бэлэг, шагнал урамшуулал олгосон" гэжээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, Засгийн Газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

6.1. Завсрын аудитын үр дүн:

Завсрын аудитаар 1,467,559.6 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 1,071,058.4 мянган төгрөгийн 6 алдааг залруулж, 391,244.3 мянган төгрөгийн шилэн дансны мэдээллийг нөхөн шивж, 1 төлбөрийн акт хэрэгжээгүй байна.

6.2. Өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилт:

Өмнөх оны аудитаар 124,730.4 мянган төгрөгийн 9 зөрчил илэрснээс 5,808.9 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 110,189.8 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 8,731.7 мянган төгрөгийн 5 зөвлөмж өгснөөс акт 10 хувь, албан шаардлага 33 хувь, зөвлөмж 100 хувийн биелэлттэй байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, акт, албан шаардлагын хэрэгжилт

/сая төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Төлбөрийн акт	1	5.8	0.10	0.6	0.90	5.2	10.0
Албан шаардлага	3	110.2	2	106.4	1	3.8	33.0
Зөвлөмж	5	8.7	5	8.7	-	-	100.0
Нийт дүн	9	124.7	7.1	115.7	1.9	9.0	44.34

Төлбөрийн актын хэрэгжилт хангалтгүй тул албан шаардлага өгөв.

7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Шалгагдагч байгууллагын шинээр баригдаж байгаа объектийн гүйцэтгэл, түрээсийн асуудалд дараагийн аудитаар анхаарал хандуулах нь зүйтэй гэж үзлээ.

8. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,095,956.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 1,041,701.3 мянган төгрөгийн 2 алдааг залруулж, 216.8 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 26,980.9 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 27,057.8 мянган төгрөгийн 6 алдаа зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 32,531.5 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 115,234.0 мянган төгрөгийн материаллаг байдлын түвшингээс 82,702.5 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

8.1 Залруулсан алдаа

Санхүүгийн тайланд нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 1,041,701.3 мянган төгрөгийн 2 алдааг залрууллаа. Үүнд:

- Мөнгөн гүйлгээний тайланд 1,034,000.0 мянган төгрөгийн зардлын эдийн засгийн ангиллын алдааг залруулсан
- Голомт банк дахь харилцах дансны 7,701.3 мянган төгрөгийн үлдэгдэл залруулсан.

8.2 Төлбөрийн акт

Ажилтнуудад 216.8 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5, ".....ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоов.

8.3 Албан шаардлага

1. Өмнөх аудитын шалгалтаар өгөгдсөн 5,808.9 мянган төгрөгийн төлбөрийн актаас 552.0 мянган төгрөгийг барагдуулж 5,256.9 мянган төгрөг барагдуулаагүй.

Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1."Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөв.

8.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Урт хугацаат өглөгтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/582 дугаар захирамжаар Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн каунти, дэйвү маркын 60 ширхэг автобусны шилжиж ирсэн 6,145,526.0 мянган төгрөгийн өр, Нийтийн тээврийн газраас 2021 онд шилжиж ирсэн 1,536,666.7 мянган төгрөгийн хүүхдийн 5 автобусны өр эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1."Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх батламж мэдээдлийг хангахагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн 60 ширхэг каунти, дэйвү маркийн автобус, хүүхдийн 5 автобусны өрийн үлдэгдлийн асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлэх

2. Урьдчилж төлсөн зардлын үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

2020 оны 5 дугаар сард урьдчилж төлсөн даатгалын 18,996.2 мянган төгрөгийн зардлыг даатгалын гэрээний хугацаанд зардалд хааж дансны бичилт хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2."Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Урьдчилж төлсөн даатгалын төлбөрийг улирлын төгсгөл бүрд зардлын дансанд бичилт хийж байх

3. Авлага дансны үлдэгдэлтэй холбоотой асуудал

Илрүүлэлт:

НДШ-ийн 5,830.8 мянган төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй, өрийн үлдэгдлээс хасаж тооцсон эсэх нь тодорхойгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 "Дансны авлага, өглөг ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй, тохиолдсон байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: НДШ-ийн авлагын оны эхний үлдэгдэл 4,838.2 мянга, тайлант оны гүйлгээний зөрүү 992.6 мянган төгрөгийн тооцоог тодруулж, шийдвэрлэх

4. Зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт:

Хөгжлийн банкнаас авсан зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт төлсөн 18,700.0 мянган төгрөгийн зардлыг зээлийн үндсэн хүүгийн адилаар зээлийн хүүгийн зардалд бүртгэсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2."Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрийг үйл ажиллагааны бус зардал буюу алданги торгуулийн зардалд бүртгэх.

5. Дотоод хяналттай холбоотой асуудал

Илрүүлэлт:

2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/14 тоот тушаалыг зөрчиж нэр бүхий 6 хүнд 8,061.6 мянган төгрөгийн цалин олгосон. Завсрын аудитаар ажлын шаардлагаар ажиллуулсан гэх тайлбар өгч, 2021 оны 12 дугаар сард тушаалыг нөхөн гаргасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2."Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: 20.2.3."холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж:

Ажиллагсдыг сул зогсоох, сул зогсолтын цалин олгох, ажлын шаардлагаар эргүүлэн ажиллуулахад тухай бүр тушаал гаргаж байх.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллага болон аудитын хуулийн этгээдэд 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Загваруулга		Акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн асуудлаар																
1	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Мөнгөн гүйлгээний тайланд 1,034.0 сая төгрөгийн зардлын эдийн засгийн ангилалын алдааг залруулсан	Зөрчлийг даатгахгүй байх	1	1,034,000.0	1	1,034,000.0								
2	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Голомт банкн дахь харилцах дансны 7.7 сая төгрөгийн үлдэгдэл залруулсан	Зөрчлийг даатгахгүй байх	1	7,701.3	1	7,701.3								
3	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	2021 оны 10-12 дугаар сард илүү цалин олгосон	Зөрчлийг даатгахгүй байх	1	216.8			1	216.8						
4	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Өмнөх аудитын шалгалтаар өгөгдсөн 5,808.9 мянган төгрөгийн төлбөрийн актнаас 552.0 мянган төгрөгийг барагдуулж 5256.9 мянган төгрөг барагдуулаагүй	Хуулийн байгууллагаар асуудлыг шийдвэрлүүлэх	1	5,256.9					1	5,256.9				
5	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	2021 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн А/14 тоот тушаалыг зөрчиж нэр бүхий 6 хүнд цалин олгосон /актын шаардлагаар ажиглуулсан гэх боловч тушаал гаргаагүй/	Зөрчлийг даатгахгүй байх	1	8,061.8									1	8,061.8

Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

6	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	2020 оны 5 дугаар сард урьдчилж төлсөн даатгалын 19.0 сая төгрөгийн зардлыг даатгалын гэрээний хугацаанд зардалд хааж дансны бичигт хийгээгүй	Зөрчлийг даатгахгүй байх	1	18,996.2										1	18,996.2
7	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Хөгжлийн банкнаас авсан зээлийн нэмэгдүүлсэн хүүгийн төлбөрт төлсөн 18.7 сая төгрөгийн зардлыг зээлийн үндсэн хүүгийн адилаар зээлийн хүүгийн зардалд бүртгэсэн.	Зөрчлийг даатгахгүй байх	1	-										1	-
8	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	НДШ-ийн 5.8 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулаагүй.	Зөрчлийг даатгахгүй байх	1	5,830.8										1	5,830.8
9	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Зорчигч тээврийн нэгтгэл ОНӨААТҮГ-аас шилжих ирсэн 6,145.5 сая төгрөгийн өр нь Нийслэлийн Засаг даргын 2015 оны А/582 дугаар захирамжаар Нийслэлийн нийтийн тээврийг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр нийлүүлэгдсэн каунти, дэйнэ 80 ширхэг автобусны өр, Нийтийн тээврийн газраас 2021 онд шилжих ирсэн 1,536.6 сая төгрөгийн хүүхдийн 5 автобусны өрийн эргэн төлөгдөх эсэх нь тодорхойгүй байна.	Зөрчлийг даатгахгүй байх	1	-										1	-
				ДҮН	9	1,080,063.8	2	1,041,701.3	1	216.8	1	5,256.9	0	0	5	32,888.6	

Санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал

1	Зорчигч тээвэр гурав ОНӨАА ТҮГ	ХАК-2022/67/Н А-СА-ОНА	Шилэн дансны тухай хуулийн 6.4.5 дахь заалтыг зөрчин орлогын 11 гүйлгээ буюу 2,052.9 сая төгрөг, зарлагын 2 гүйлгээ буюу 33.0 сая төгрөг, нийт 13 гүйлгээний 2,085.9 сая төгрөг шилэн дансанд оруулаагүй байна	Зөрчлийг даатгахгүй байх	1	2,085,927.2						1	2,085,927.2				
---	--------------------------------	------------------------	--	--------------------------	---	-------------	--	--	--	--	--	---	-------------	--	--	--	--



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 108/1202059
АМ-2022/67/НТ-ОНА

Улаанбаатар хот

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Тайлант онд ажилтнуудад 216,800.00 /хоёр зуун арван зургаан мянга найман зуу/төгрөгийн цалинг илүү бодож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "үнэн зөв байх", 20 дугаар зүйлийн 20.2.5, ".....ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөө, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.3-д "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон тохиолдолд төлбөрийн акт тогтооно" заалтуудыг үндэслэн ТОГТООХ нь:

1. "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын ажилтнуудад илүү бодож олгосон цалингийн 216,800.00 (хоёр зуун арван зургаан мянга найман зуу) төгрөгийг холбогдох албан тушаалтнаар төлүүлж Нийслэлийн Төрийн сангийн төсвийн орлогын Нийслэлийн Төрийн сан дахь 100200000908 тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт¹ ирүүлэхийг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

"БЭСТ ФОРТУНА АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ

Ж.ОЮУНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 349/12025059

Улаанбаатар хот

ХЯН-2022/67/НН-НН-ОНН

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулах 29 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.4.5 "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" зэргийг долоо хоногийн дотор мэдээлнэ" заалтуудыг зөрчсөн байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Шилэн дансны мэдээлэл хугацаанд нь байршуулах тухай өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлангийн хугацаанд дээрх зөрчлийг давтан гаргасан зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 05 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН¹:

"БЭСТ ФОРТУНА АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ж.ОЮУНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР



З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР



С.ГАНТӨГС



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 350/202205
ХТМ-2022/17/МН-ОМН

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Өмнөх аудитын шалгалтаар өгөгдсөн 5,808,909.00 /таван сая найман зуун найман мянга есөн зуун ес/ төгрөгийн төлбөрийн актаас 552,000.00 /таван зуун тавин хоёр мянга/ төгрөгийг барагдуулж 5,256,909.00 /таван сая хоёр зуун тавин зургаан мянга есөн зуун ес/ төгрөгийг барагдуулаагүй байна. Энэ нь Төрийн аудитын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1. "Төрийн аудитын байгууллага хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг Захиргааны ерөнхий хуулийн 82, 83 дугаар зүйлд заасан журмаар гүйцэтгэнэ", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5, "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Өмнөх аудитаар тогтоосон төлбөрийн актын үлдэгдэл 5,256,909.00 (таван сая хоёр зуун тавин зургаан мянга есөн зуун ес) төгрөгийг барагдуулаагүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 25-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН¹:

"БЭСТ ФОРТУНА АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ж.ОЮУНЦЭЦЭГ

ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР

З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

С.ГАНТӨГС



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 351/19095059

Улаанбаатар хот

ХМ-2022/67/НБ-ОА-ОП

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Зорчигч тээвэр гурав ОНӨААТҮГ-ын 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- Шинэ жилийн баяраар бэлэг өгсөн, спортын тэмцээн зохион байгуулсан, төрийн шагнал хүртэгсдэд шагнал урамшуулал олгосон зэрэг нийт 21,724,000.00 /хорин нэгэн сая долоон зуун хорин дөрвөн мянга/ төгрөгийг зарцуулсан нь Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.6 "Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх;" заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." заалтуудыг үндэслэн ШААРДАХ нь:

1. Эрх бүхий дээд байгууллагын гаргасан шийдвэрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 5 дугаар сарын 10-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг "Зорчигч тээвэр гурав" ОНӨААТҮГ-ын дарга О.Ганбаатар, Санхүү бүртгэлийн хэлтсийн дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч Б.Баярцэцэг нарт хариуцуулав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН¹:

"БЭСТ ФОРТУНА АУДИТ"
ХХК-ИЙН ЗАХИРАЛ



Ж.ОЮУНЦЭЦЭГ


ХЯНАСАН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ХЭЛТСИЙН
ДАРГА, АУДИТЫН МЕНЕЖЕР



З.МӨНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР



С.ГАНТӨГС



¹ Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 4 давхар